



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 2/72

Мандалговь

“Ашид бьюлдинг” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Засаг даргын Тамгын газрын барилгын засвар” /Дундговь, Дэлгэрцогт сум/-ийн гүйцэтгэгчээр шалгарсан “Ашид бьюлдинг” ХХК-тай 284,244,473 (хоёр зуун наян дөрвөн сая хоёр зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун далан гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Засварын ажлыг батлагдсан зураг, төсвийн дагуу нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ашид бьюлдинг” ХХК-ний захирал (О.Мөнхсаруул)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

481150162